



**ХЭНТИЙ АЙМГИЙН  
БАЯН-АДАРГА СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/40

Баян-Адарга

Г

Г

Мал амьтны шимэгчтэх өвчнөөс  
эмчлэн сэргийлэх арга хэмжээг  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1дэх хэсэг, 60 дугаар зүйлийн 60.1.13 дахь заалт, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.3 дахь хэсэг, 21.3.1, 21.3.2 дахь заалт, Хэнтий аймгийн Засаг даргын 2026 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/156 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын нутаг дэвсгэрт байгаа төлөвлөгөөт мал амьтныг угаалга, туулгалт, боловсруулалтад хамруулах арга хэмжээг 2026 оны 04 дүгээр сарын 01-ны өдрөөс эхлэн зохион байгуулсугай.

2.Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээг мал эмнэлгийн график хугацаанд багтаан чанартай зохион байгуулж ажиллахыг багийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3.Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээг зохион байгуулахад мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, уг арга хэмжээнд мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлс хийж заавар журмыг баримтлаагүй малчин, мал бүхий иргэд холбогдох албан тушаалтанд хуулийн дагуу хариуцлага тооцож, хяналт тавьж ажиллахыг Мал Эмнэлгийн Хяналтын Улсын байцаагч (Э.Оюунтунгалаг)-т даалгасугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын Орлогч (Н.Ганбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  О.ЛХАГВАДОРЖ

